



# ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС

## төрийн өмчит үйлдвэрийн газар



**2025 оны үйл ажиллагааны  
тайлан**

## 1. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газар нь БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 1973 онд Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэс критикал минералс” нэгдэл нэртэйгээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хайлуур жонш, үнэт металл болон бусад төрлийн ашигт малтмалыг олборлон баяжуулах, эрдэс түүхий эдийн нөөцийг өсгөх, улсын экспортын чадавхыг нэмэгдүүлэх зорилготойгоор байгуулагдан эдүгээ 52 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байгаа Монгол Улсын анхны гадаадын хөрөнгө оруулалттай томоохон аж ахуйн нэгж юм.

Хамтарсан нэгдэл 2007 оноос хязгаарлагдмал хариуцлагатай компани, 2019 оноос Төрийн өмчит үйлдвэрийн газар болж өөрчлөгдөн үйл ажиллагаа явуулж байна.

Өмнөх 1973 оноос 2016 он хүртэл Үйлдвэрийн газрын Дүрмийн сангийн 51% Монгол Улсын, 49% нь ОХУ-ын өмчлөлд байсан бөгөөд 2016 оноос Монгол Улсын 100% төрийн өмчийн эзэмшилд шилжсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 95 дугаар тогтоолоор “Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газрын нэрийг “Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилж, чухал ашигт малтмал болон газрын ховор элементийн судалгаа, хайгуул, олборлолт, ашиглалт, боловсруулалтын чиглэлээр үйл ажиллагааг өргөтгөн дүрмийг шинэчлэн баталсан.

### “Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газрын бүрэлдэхүүн

Зураг 1. Үйлдвэрийн газрын бүрэлдэхүүн

Төрийн өмчит үйлдвэрийн газар хэлбэрээр, бүтэц бүрэлдэхүүндээ 1752 ажилтантайгаар, Баргилт, Зүүн цагаан дэл, Шижир алт гэсэн 3 уурхайд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн.




“Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газрын зорилго нь геологи, уул уурхай, олборлох, баяжуулах, боловсруулах чиглэлээр дэлхийд өрсөлдөхүйц, олон улсын жишигт хүрсэн сайн засаглал, технологи, чадавх бүхий үйлдвэрлэл явуулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар Монгол Улсын эдийн

засгийн өсөлтийг дэмжих, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээхэд оршино.

Үйлдвэрийн газар нь хайлуур жонш, алт, төмрийн хүдэр, газрын ховор элемент болон бусад чухал ашигт малтмал олборлох, баяжуулах, борлуулах, хайрга, дайрга, элс үйлдвэрлэл, геологи хайгуулын ажлын чиглэлээр тус тус үйл ажиллагаагаа явуулан, жилд 100 мянган тонн хайлуур жоншны хүдэр, 2.2 сая тонн төмрийн хүдэр олборлон, 1.5 сая тонн төмрийн хүдэр боловсруулан 800 мянган тонн төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэх, 110 - 120 мянган тонн жоншны баяжмал үйлдвэрлэн экспортлох хүчин чадалтай.

Зураг 2. Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, үйл ажиллагааны туршлага



Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хот дахь Захиргаа, Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд орших “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэр, Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Шижир алт” алтны үйлдвэр, Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв гэсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. 2025 оны байдлаар нийтдээ 1644 хүнийг ажлын байраар тогтмол ханган ажилласан байна.

### Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүтэц

Зураг 3. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүтэц



## 2. ЭРХ БҮХИЙ ДЭЭД БАЙГУУЛЛАГААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ, ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

Үйлдвэрийн газар нь 2025 онд Засгийн газар, төрийн захиргааны байгууллага болон эрх бүхий дээд байгууллагаас нийт 288 албан тоот, тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгавар, чиглэлийг цаг хугацаанд биелүүлж ажилласан болно. Үүнд ТӨБЗГ-аас 15, “Эрдэнэс Монгол” ХХК-иас 193, бусад төрийн байгууллага яамны 80 албан тоот, тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгавар, чиглэлийг цаг хугацаанд нь биелүүлж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан.

“Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ нь Монгол Улсын хууль тогтоомж, Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангах, мөн “Эрдэнэс Монгол” ХХК-аас өгсөн үүрэг, даалгаврыг үйл ажиллагаандаа тухай бүр хэрэгжүүлэн ажилласан.

- Тухайлбал, хууль тогтоомж болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийн талаарх тайлан, мэдээллийг 2025 онд “Эрдэнэс Монгол” ХХК-д нийт 3 удаагийн албан бичгээр хүргүүлэн тайлагнасан.
- ТӨҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан.
- Монгол Улсын Засгийн газрын холбогдох тогтоол, тэмдэглэл, албан даалгаврыг үйл ажиллагаандаа нийцүүлэн хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар “Эрдэнэс Монгол” ХХК-д тогтмол тайлагнан ажилласан.

Мөн холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын төсөлд тухай бүрд санал өгч ажилласан бөгөөд Үйлдвэрийн газрын тушаал, шийдвэрийн төслийн эрх зүйн үндэслэлийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлэн ажиллаж байна.

### 3. ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ТАЙЛБАР

“Бор-Өндөр” УБҮ-ийн Уулын цех нь “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-аас батлагдсан үйлдвэрлэлийн үйл ажиллагааны 2025 оны батлагдсан төлөвлөгөөг мөрдлөг болгон Бор-Өндөр хэсгийн далд уурхай, Зүүн цагаан дэл хэсгийн далд уурхай, Баргилтын ил уурхайд уулын үйлдвэрлэлийн технологийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

#### 3.1. Баргилтын төмрийн хүдрийн ил уурхай

Баргилтын төмрийн хүдрийн ил уурхайд 2025 онд хүдэр олборлолт 2,000.0 мян.тн, хөрс хуулалт 4,011.812 мян.м3, уулын цул 4,529.947 мян.м3, өрөмдлөг 272,700 тууш метр уулын ажлын төлөвлөгөө батлуулан 1560-1420м түвшинд уулын ажлын өрнөл явагдлаа. Баргилтын ил уурхайн хөрс хуулалтын ажил 98%-н биелэлтэй бусад уулын ажлын бүх үзүүлэлт 100%-с давуулан биелүүлж ажилласан.

Уулын ажлын гүйцэтгэлийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Баргилтын төмрийн хүдрийн ил уурхайн уулын ажлын гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэм.	2025 он		
			Нэгж	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Хүдэр олборлолт	мян.тн	2,000,000	2,105,585	105.28
2	Хөрс хуулалт	мян.м3	4,011.812	3,896.156	98.10
3	Хөрс хуулалтын коэф.	м3/тн	2.01	1.85	92.12
4	Өрөмдлөг	мян.т.м	272.700	275.418	101.0
5	Уулын цул	мян.м3	4,529.947	4,441.644	98.1

Уурхайгаас олборлосон хүдрийн тодорхой хэсгийг Хуурай соронзон баяжуулалтын завсрын бүтээгдэхүүн болох өндөр агуулгатай хүдэртэй хольж агуулгыг нэмэгдүүлж, “Бор-Өндөр” УБҮ-ийн баяжуулах фабрикт нойтон соронзон аргаар баяжуулж, Fe-65 маркийн төмрийн нойтон баяжмал үйлдвэрлэж байна.

Тус баяжуулах фабрикт 2025 онд 470.470 мян.тн хүдэр боловсруулж, 225.365 мян.тн Fe-65 төмрийн нойтон баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөн ажилласан.

Тайлант хугацааны гүйцэтгэлээр 337.203 мян.тн хүдэр боловсруулж, Fe-65 төмрийн нойтон баяжмал 152.597 мянган тонныг, Zn-50 цайрын баяжмал 0.263 мянган тонныг тус тус үйлдвэрлэж ажилласан. Төмрийн хүдрийн баяжмалын нийт металл авалт 102% гүйцэтгэлтэй байна. Баяжуулах фабрикийн төмрийн хүдэр боловсруулалтын үзүүлэлтүүдийг хүснэгтээр харууллаа.

Баргилтын уурхайн Хуурай соронзон баяжуулах №1 үйлдвэрт 504.7 мян.тн хүдэр боловсруулж, Fe-52 маркийн төмрийн хуурай баяжмал 224.6 мян.тн үйлдвэрлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 550.3 мян.тн хүдэр боловсруулж, 245.4 мян.тн Fe-52 төмрийн хүдрийн хуурай баяжмал үйлдвэрлэж төлөвлөгөөг 109.3%-иар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Хуурай соронзон баяжуулах 1-р хэсгийн хүдэр боловсруулалтын үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Хэм нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	
					%	Өсөлт+, бууралт-,
1	БФ-т боловсруулсан хүдэр	тн	504706	550264	109.03	45558
2	Нийт бүтээгдэхүүн гаргалт	тн	325737	355430	109.12	29693

Баргилтын уурхайн Хуурай соронзон баяжуулах №2 үйлдвэрт 600.0 мян.тн хүдэр боловсруулж, Fe-52 маркийн төмрийн хуурай баяжмал 267.0 мян.тн үйлдвэрлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 623.3 мян.тн хүдэр боловсруулж, 280.8 мян.тн Fe-52 төмрийн хүдрийн хуурай баяжмал үйлдвэрлэж төлөвлөгөөг 105.2 %-н биелүүлэлтэй ажилласан байна.

Хүснэгт 3. Хуурай соронзон баяжуулах №2-р хэсгийн хүдэр боловсруулалтын үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Хэм нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	
					%	+-
1	БФ-т боловсруулсан хүдэр	тн	600000	623301	103.88	23301
2	Нийт бүтээгдэхүүн гаргалт	тн	387241	405632.7	104.75	18392

Мөн 2025 оны бизнес төлөвлөгөөнд гаднын байгууллагатай гэрээ байгуулан хуурай соронзон аргаар 600.0 мян.тн хүдэр боловсруулахаар тусгагдсан. 2025 оны гүйцэтгэлээр гэрээт байгууллагаар 781.4 мян.тн хүдэр боловсруулалт хийлгэж 365.2 мянган тонн баяжмал, ажилласан.

Хүснэгт 4. Гадны байгууллагаар гүйцэтгүүлсэн хүдэр боловсруулалтын ажлын үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэм. нэгж	2025 он	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Боловсруулалт Агуулга Fe	мян.тн. %	600.000	781.405
			33.30	33.24
2	Завсрын бүтээгдэхүүн гаргалт	мян.тн	220.0	258.4

Мөн хуурай соронзон баяжуулалтаас гарсан бага агуулгатай (20%-24%) 300.0 мян.тн завсрын бүтээгдэхүүнийг дахин боловсруултанд оруулж агуулгыг нэмэгдүүлэн 151.1 мян.тн 32.5% агуулгатай завсрын бүтээгдэхүүн болгон авч нойтон баяжуулах үйлдвэрийн түүхий эдээр ашиглан гэрээгээр Fe-65 баяжмал үйлдвэрлүүлэх туршилтын ажлыг гүйцэтгэсэн.

Хүснэгт 5 гадны байгууллагаар гүйцэтгүүлсэн Fe-65 баяжмал үйлдвэрлэлийн ажлын үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэм. нэгж	Гүйцэтгэл
1	Бага агуулгатай завсрын бүтээгдэхүүн боловсруулалт	мян.тн.	300.000
2	Баяжмал гаргалт, нийт	мян.тн.	62.276

### 3.2. Зүүн цагаан дэлийн далд уурхай

2025 оны хүдэр олборлолтын төлөвлөгөө 50.0 мян.тн бөгөөд үүнээс нэвтрэлтээс олборлох хүдэр 14.160 мян.тн, олборлох хүдэр 35.840 мян.тн байхаар төлөвлөн ажилласан. 2025 онд хүдэр олборлолтын гүйцэтгэл 50.133 мян.тн буюу 100.27% биелэлттэй байна. Хүдрийн агуулга 32.79% байсан ба төлөвлөгөөт 31.40 % агуулгыг 104.42% биелүүлсэн.

2025 оны 4-р улиралаас эхлэн Зүүн цагаан дэл далд уурхайн үндсэн хүдэр олборлолтын ажлыг +1150 түвшингийн 7-р хүдрийн биетийн блокуудаас хийж гүйцэтгэсэн.

2025 онд далд уурхай нь 1896 у.м/ 9209 м<sup>3</sup> төлөвлөснөөс 1981.5 у.м/13,385 м<sup>3</sup> нэвтрэлтийн ажил гүйцэтгэж, төлөвлөгөөний биелэлт 104.51%/145.35% гүйцэтгэлтэй төлөвлөгөөт үзүүлэлтээ биелүүлж ажилласан.

Далд уурхайн хүдрийн нөөц бэлтгэлээр 1150 м түвшинд 1-р хүдрийн биет болон 7-р хүдрийн биетэд үндсэн, бэлтгэл малталт, ашиглалт хайгуулын малталтуудыг хийж гүйцэтгэн 2025 оны 4-р улиралаас хүдэр олборлолтын ажлыг эхлүүлээд байна.

Мөргөцөгт шпур өрөмдлөгийн ажлыг УТ-28 өрмийн төхөөрөмжөөр, цооног өрөмдлөгийн ажлыг КХД-100 маркын суурин өрмийн төхөөрөмжөөр гүйцэтгэн, өөрөө явагч ачигч зөөгч машин ХДСУ-2, автосамосвал УК-12 техникүүдийг ашиглан нэвтрэлтийн ажлаас гарах уулын цул болон олборлосон хайлуур жоншны хүдэр тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Хүдэр олборлолтын ажил эхлэхтэй холбогдуулан 2025 онд авто ачигч ХДСУ-2, автосамосвал УК-12 шинээр хөрөнгө оруулуулалтаар худалдан авсан.

Хүснэгт 6 Зүүн цагаан дэлийн далд уурхайн уулын ажлын гүйцэтгэл

№	Үзүүлэлт	хэмжих нэгж	2025 онд		
			төлөвлөгөө	гүйцэтгэл	биелэлт,%
1	Хүдэр олборлолт. Нийт:	мян.тн.	50,000.00	50,133.00	100.27
4	Зүүн цагаан дэл нийт нэвтрэлтийн ажил	т.м	1,896.02	1,981.50	104.51
		м3	9,209.00	13,385.00	145.35
5	Уулын үндсэн малталт	т.м	427.42	78.00	18.25
		м3	2,587.40	343.20	13.26
6	Уулын бэлтгэл малталт	т.м	1,322.60	1,553.00	117.42
		м3	6,055.60	11,124.70	183.71
7	Ашиглалтын хайгуулын малталт	т.м	146.00	350.50	240.07
		м3	566.00	1,917.10	338.71

### 3.3. Жоншны хүдрийн боловсруулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тайлан

“Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэрийн баяжуулах үйлдвэр нь төмрийн хүдэр болон жоншны хүдэр боловсруулах 2 шугамтай бөгөөд одоогоор төмрийн хүдэр боловсруулан Fe-65 баяжмал үйлдвэрлэх шугамын голчлон ашиглаж байна.

2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс жоншны хүдэр боловсруулах горимд шилжин ажиллаж 175.5 мян.тн хүдэр боловсруулж 243.9 тонн ФК-75 бүхэллэг жонш ялгаж, 29,3 мян.тн ФФ-95 маркийн флотацийн баяжмал үйлдвэрлэсэн байна.

Хүснэгт 7 Жоншны хүдэр баяжуулах ажлын гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэм нэгж	Тодотгол төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	
					+ -	%
1	БФ-т боловсруулсан хүдэр	тн	162096	175455	13359	108.24
2	Баяжмалын гаргалт	тн	30438	29338	-1100	96.39

2021 оноос 2025 оныг хүртэлх хугацаанд жоншны хүдэр боловсруулах горимоор ажиллаагүй байсан үйлдвэр нь 6-р сарын 10-ны өдрөөс тус горимд шилжин ажилласан. Хүдрийн овоолго дахь жоншны СаF<sub>2</sub>-н дундаж агуулга бага, хүдрийн ширхэглэлийн хэмжээ ерөнхийдөө 70% нь нунтаг байсан нь баяжмалын эрдэс авалт, гарц, хаягдлын агуулгад нөлөөлсөн.

Мөн гадны байгууллагаар гэрээгээр 68.6 мян.тн жоншны хүдрийн боловсруулалт хийлгэж 15.1 мян.тн ФФ-97 маркийн баяжмал үйлдвэрлүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 45.7 мян.тн хүдрийн боловсруулалт хийлгэж 9.1 мян.тн баямал үйлдвэрлүүлэн эксдортолсон байна.

### 3.4. “Даваатын алтны шороон орд” ил уурхайн батлагдсан төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 8 Шижир Алт алтны үйлдвэрийн уулын ажлын гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэм.	2025 онд		
		нэгж	төлөвлөгөө	гүйцэтгэл	биелэлт,%
1	Металл олборлолт	кг	77.3	22.831	29.54
2	Хөрс хуулалт	мян.м3	1284.4	1203.8	93.72
3	Элс олборлолт.	м3/тн	89.4	67.9	75.9
4	Элс боловсруулалт	мян.т.м	89.4	67.9	75.9

Даваатын хөндийн алтны шороон ордод 2025 онд уулын ажлын төлөвлөгөөнөөс хөрс хуулалт, элс олборлолт, боловсруулалт дутуу гүйцэтгэлтэй. Шалтгаан нь уурхай бичиг баримтын бүрдэл, Туул голоос ус татах болон усан шахуургын тендертэй холбоотой байсан.

Даваатын алтны шороон ордод 2023 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн нөөц болох 2024 оны 06 сарын 13-ны өдрийн ХХ-07-05 тоот Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт дэх нөөцийн 1-С', 2- В', 3- С', 18-В, 19-В, 20-В, 21-В блокийн дундаж агуулга, блокийн металлын нөөц дээжлэлтийн үед болон элс боловсруулалтын үед батлагдаагүй нь дундаж агуулга 57,64-82,35% зөрүүтэй байгаа нь гол шалтгаан байлаа.

1-С' блок олборлолтын үеийн 7 шурфын болон бөөн дээжлэлтээр 16,4 мг/м<sup>3</sup> гэж тооцсон, уулын ажлын төлөвлөгөө 6,25 мян.м<sup>3</sup> элс олборлож, 254,3 мг/м<sup>3</sup> агуулгатай 6,25 мян.м<sup>3</sup> элс боловсруулж 1,28 кг металл олборлохоос гүйцэтгэлээр 1,60 мян.м<sup>3</sup> элс олборлож, 50 мг/м<sup>3</sup> агуулгатай 1,60 мян.м<sup>3</sup> элс боловсруулж 0,07 кг металл олборлосон нь гүйцэтгэл 94,93% зөрүүтэй, дундаж агуулга 80,34% зөрүүтэй байна.

2- В', 3- С' блок олборлолтын үед 10 шурфын 64 ширхэг дээжлэлт хийснээс 6 дээжид 1-2 тэмдэгт илэрсэн тул боловсруулаагүй.

18-В блок олборлолтын үед 2 хувааж нээсэн нийт 13 шурфын 91 ширхэг дээжлэлтээр 587,0 мг/м<sup>3</sup> гэж тооцсон, уулын ажлын төлөвлөгөө 37,08 мян.м<sup>3</sup> элс олборлож, 1127,78 мг/м<sup>3</sup> агуулгатай 37,08 мян.м<sup>3</sup> элс боловсруулж 33,86 кг металл олборлохоос гүйцэтгэлээр 42,13 мян.м<sup>3</sup> элс олборлож, 347,63 мг/м<sup>3</sup> агуулгатай 42,13 мян.м<sup>3</sup> элс боловсруулж 16,74 кг металл олборлосон нь гүйцэтгэл 59,74 % зөрүүтэй, дундаж агуулга 69,18% зөрүүтэй байна.

19-В блок олборлолтын үед 2 хувааж нээсэн нийт 8 шурфын 5 хананы 47 ширхэг дээжлэлтээр 380,7 мг/м<sup>3</sup> гэж тооцсон, уулын ажлын төлөвлөгөө 12,15 мян.м<sup>3</sup> элс олборлож, 2108,20 мг/м<sup>3</sup> агуулгатай 12,15 мян.м<sup>3</sup> элс боловсруулж 20,75 кг металл олборлохоос гүйцэтгэлээр 12,95 мян.м<sup>3</sup> элс олборлож, 372,04 мг/м<sup>3</sup> агуулгатай 12,95 мян.м<sup>3</sup> элс боловсруулж 4,82 кг металл олборлосон нь гүйцэтгэл 78,39 % зөрүүтэй, дундаж агуулга 82,35% зөрүүтэй байна.

20-В блок олборлолтын үед нийт 6 шурфын 30 ширхэг дээжлэлтээр 345,0 мг/м<sup>3</sup> гэж тооцсон, уулын ажлын төлөвлөгөө 8,03 мян.м<sup>3</sup> элс олборлож, 1306,9 мг/м<sup>3</sup> агуулгатай 8,03 мян.м<sup>3</sup> элс боловсруулж 8,50 кг металл олборлохоос гүйцэтгэлээр 9,68 мян.м<sup>3</sup> элс олборлож, 401,56 мг/м<sup>3</sup> агуулгатай 12,95 мян.м<sup>3</sup> элс боловсруулж 4,82 кг металл олборлосон нь гүйцэтгэл 78,39 % зөрүүтэй, дундаж агуулга 69,27% зөрүүтэй байна.

21-В блок олборлолтын үед нийт 2 шурфын 12 ширхэг дээжлэлтээр 302,0 мг/м<sup>3</sup> гэж тооцсон, гүйцэтгэлээр 1,52 мян.м<sup>3</sup> элс олборлож, 313,11 мг/м<sup>3</sup> агуулгатай 1,52 мян.м<sup>3</sup> элс боловсруулж 0,48 кг металл олборлосон. Дундаж агуулга 57,64% зөрүүтэй

Олборлолтын үед 20-В олборлох үед 21-В блокд олборлолтод өртсөн хэсэг.

22-С блок төлөвлөгөөнд тусгагдсан боловч 2025 онд олборлолт явуулаагүй.

Баяжуулалтын хөндлөнгийн технологийн хяналт сорьцлолтын ажлыг “АМБ лаб” ХХК 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр ЕСМР-2025-02-37 тоот гэрээний дагуу 2025 оны 09 дугаар сарын 23 -ны өдөр гүйцэтгэсэн.

Судалгааны үр дүнгээр алт агуулсан элсийг гравитацийн аргаар буюу скруббер-шлюзний хослол бүхий угаах төхөөрөмж ашиглан баяжуулж байгаа ба нийт металл авалтын хэмжээ 90.12% байна.

Элсний дундаж агуулгыг шинжилгээний үр дүнд үндэслэн 324 мг/м<sup>3</sup> байгааг тооцсон.

Мөн элсний талбайд байсан 18-В блокийн элснээс бөөн дээжлэлт хийж агуулга тогтооход 270,0 мг/м<sup>3</sup> байсан.

### **3.5. Геологи хайгуулын ажлын гүйцэтгэл**

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь өнгөрсөн 2025 онд геологи, хайгуулын болон үйл ажиллагааны чиглэлд онцлох үйл явдал болсон.

Энэ нь хуучнаар “Монголросцветмет” ТӨҮГ-ын нэрийг “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ гэж өөрчилж, чухал ашигт малтмал болон газрын ховор элементийн судалгаа, хайгуул, олборлолт, ашиглалт, баяжуулалтыг хариуцуулахаар үйл ажиллагааны чиглэлийг өргөтгөн дүрэмд өөрчлөлт оруулсан явдал юм. Ингэснээр энэ чиглэлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр авах, түүнд хайгуулын ажил гүйцэтгэх шаардлага тулгарсан.

Үүнээс гадна өмнөх жилүүдэд байгуулагдсан гэрээт ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа ба шинээр 2025 онд “Хяргас нуур”, “Хашаат Овоот Даваат”, “Өндөрцагаан-1” гэх талбайнуудад геологи хайгуулын ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хээрийн ажлыг бүрэн гүйцэтгэж ажилласан болно.

2025 онд хийж хэрэгжүүлсэн геологи хайгуулын ажлуудыг авч үзвэл:

1. Чухал ашигт малтмал болон газрын ховор элементийн судалгааны ажлын хүрээнд Монгол орны хэтийн төлөв бүхий орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүдэд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн өмнөх судлаачдын тайлан болон өөрсдийн хийж гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын үр дүнд үндэслэн критикал ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайнууд ялгаж ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг АҮЭБЯ, Монгол улсын ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох тухай” 196 дугаар тогтоол гарч тус тогтоолоор 4 талбайд ашигт малтмал хайх эрхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Эрдэнэс критикал минералс ТӨҮГ-т олгож, ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэхийг Ашигт малтмал, газрын тосны газарт даалгаж шийдвэрлэсэн ба холбогдох баримт материалыг бүрдүүлэн ажиллаж байна.

Мөн өмнө нь зөвхөн зэсийн нөөц тогтоогдож бүртгэгдсэн “Хараат” ордод гүйцээх хайгуул хийж шинээр алтны нөөцийг тогтоох, зэсийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд хайгуулын ажил гүйцэтгэх тендер шалгаруулалт зарлан “Панголин дриллинг” ХХК-тай гэрээ байгуулсан. Уг ажлын хүрээнд 48 цооног буюу 6603.0 т.м баганат өрөмдлөг, лабораторийн ажил гүйцэтгэж Хараат ордын зэс, алтны нөөцийг шинээр тодорхойлон үр дүнгийн тайлан боловсруулж дууссан ба ЭБМЗ-өөс 2 шинжээч томилогдон тайланг нягтлах ажил хийгдэж байна.

Геологи, хайгуулын ажлын хяналт, гүйцэтгэлийн чанарт онцгой анхаарч, 2025 оноос өмнөх бүх хайгуулын ажлын гүйцэтгэлийг хангуулж, гэрээг дүгнэж дууссан ба цаашид геологи хайгуулын ажлыг эрчимжүүлэх, шинээр авахаар хүсэлт гаргасан хайгуулын тусгай зөвшөөрлүүд дээр хайгуулын ажлыг гүйцэтгэж критикал ашигт малтмалын хэтийн төлөвийг тодорхойлж, нөөц тогтоох, чухал ашигт малтмалын гинжин хэлхээнд “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын оролцоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

### **3.6. 2025 оны онцлох ажлууд**

- Төмрийн хүдрийн хуурай соронзон баяжуулалтын хаягдал FE-21-24% агуулгатай завсрын бүтээгдэхүүнийг дахин боловсруулалтанд оруулах замаар Fe-34% агуулгатай завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэн нойтон баяжуулах үйлдвэрт оруулсанаар хүдрийг хаягдалгүй ашиглах боломжтой болсон. 2025 онд 147.0 мян тн дахин боловсруулсан Fe-34% агуулгатай завсрын бүтээгдэхүүнийг боловсруулан 62.3 мян.тн Fe-65 баяжмал үйлдвэрлэн борлуулж 5.3 сая \$ нэмэлт орлого олсон.
- “Бор-Өндөр” УБҮ-ийн инженер техникийн ажилтнууд нь баяжуулах фабрикийн хаягдлыг өтгөрүүлэн шүүж зайлуулах төслийг боловсруулан үйлдвэрийн хаягдлыг өтгөрүүлэн шүүж, шүүгдэс буюу 5-8%-ийн чийгтэй хаягдлыг үйлдвэрийн ойр орчмын жоншны олборлолтоос үүссэн хоосон орон зай, ухашнуудад дүүргэлт хийн хадгалах технологийн шугамыг угсарч ажилд оруулсан ба тооцооллоор хаягдлын аж ахуйд жилд дунджаар 1 тэрбум орчим төгрөгийн хэмнэлт гаргах боломжтой болсон.
- MV-018900 тоот Хяргас нуур нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрлийн нийт 7260.73 га талбайн 575.0 га буюу 7.9% талбайд Хараат ордын 2-р хүдрийн биет хэмээх зэс-алтны шинэ биет илрүүлж, улмаар 2022-2023 онд хайгуулын ажил гүйцэтгэн үр дүнгийн тайлан боловсруулж ЭБМЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн нөөцийг баталгаажуулсан. Ингэснээр В+С зэрэглэлээр 3,496.63 мян.тн хүдэрт 0,83% дундаж агуулга бүхий 28,944.84 тн зэс, 0,43 г/тн дундаж агуулга бүхий 1,509.17 кг алт, 9.29 г/т дундаж агуулгатай 32,468.03 кг мөнгө, 11,22% дундаж агуулгатай 391,978.78 тн төмрийн нөөцийг тус тус бүртгүүллээ.

- Үйлдвэрийн газрын борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны III улиралд жоншны үйлдвэрлэлийг сэргээсэнээр 39.0 мян.тн жоншны баяжмал үйлдвэрлэн 35.9 мян.тн бүтээгдэхүүн борлуулсанаар нэмэлтээр 9.2 сая \$ орлого бүрдүүлсэн байна.
- 2025 онд бүтээгдэхүүн экспортын вагон эргэлтийг 1800 вагоноор буюу 117.0 мян тн-оор экспортын ачилтын хэмжээг нэмэгдүүлж 9.3 сая \$-оор экспортын орлогыг нэмэгдүүлээд байна.

“Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газарт 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1634 ажилтан ажиллаж байсан бөгөөд үүний 12.4% буюу 202 нь инженер техникийн ажилтнууд байна.

Нийт ажиллагсдыг хүйсээр нь харьцуулбал 73.7% буюу 1205 нь эрэгтэй, 26.3% буюу 429 нь эмэгтэй, нийт ажиллагсдын дундаж наслалт 38.0 байна.

2025 онд нийт 362 хүнийг ажилд авч, 392 хүнийг ажлаас чөлөөлснөөр Үйлдвэрийн газрын хэмжээнд хүний нөөцийн хөдөлгөөн 24.0%-тай байна.

## 5. ХӨДӨЛМӨР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

### 5.1. Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь сул ажлын байранд, ажилтан шалгаруулан ажилд авахдаа байгууллагын зорилго, зорилт, чиг үүргийг мэргэжил, боловсрол, ур чадварын өндөр түвшинд хэрэгжүүлэх чадвартай, ажлын байрны шаардлагыг хангасан ажил горилогчийг сонгон шалгаруулах, шударга, эрх тэгш, ил тод байх зарчмыг баримтлан ажиллахын зэрэгцээ ажиллагсдын мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах зорилгоор мерит зарчмыг баримтлан өөрийн ажиллагсдыг шилжүүлэн, дэвшүүлэн томилон ажиллаж байна.

Тайлант 2025 онд хүний нөөцийн ил тод байдлыг хангах хүрээнд 92 сул орон тоо, ажлын байрны зарыг Үйлдвэрийн газрын вэб сайт, facebook хаяг, пэйж хуудас, Бор-Өндөр УБҮ-ийн Захиргааны дэргэдэх Мэдээлэл сурталчилгаа, орон нутгийн нүүр номын “Бор-Өндөр шуурхай зар, Бор-Өндөр зарын групп, Уул уурхайн нэгдсэн зар Ажлын зар, Уул уурхайн ажлын зар, Бор-Өндөр Улаанбаатар такси зар, Хэнтий зар групп, Бор-Өндөр, Дархан, Баянмөнх, Иххэт сумын засаг захиргааны болон тус үйлдвэрийн зарлалын самбар, Шижир-Алт АҮ-ийн вэб сайт, Заамар сум, Булган аймгийн Бүрэгхангай сумын facebook нэгдсэн групп, Хайлааст 3 дугаар багийн нэгдсэн групп, үйлдвэрийн ажилтнуудын групп, үйлдвэр дээрх зарлалын самбарт болон орон нутгийн засаг захиргааны байгууллагад орон тоо нөхөгдөх хүртэл давтамжтайгаар олон нийтэд нээлттэй зарлан мэдээлэх болон харьцуулалтын аргаар нөөцөөс нөхөх сонгон шалгаруулалтыг явуулсан. Зарын дагуу болон нөөцөд бүртгэлтэй 545 /эмэгтэй 165, эрэгтэй 380/ иргэдээс сонгон шалгаруулалтыг зохион байгуулж шинээр 362 ажилтныг ажилд томилсон.

Үйлдвэрийн газрын хэмжээнд дотоод зохион байгуулалт, ажилтнуудын ур чадвар, сул орон тоог дотоод нөөц бололцоог ашиглан мерит зарчмаар шийдвэрлэх хүрээнд удирдлагын санал болон ажилтны хүсэлтийн дагуу шаардлага хангасан 50 ажилтныг дэвшүүлэн, 945 ажилтныг шилжүүлэн, томилон ажиллуулсан байна.

## 5.2. Ажиллагсдын нийгмийн хамгаалал

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь 2025 онд 242 ажилтны ажлын амжилт, хөдөлмөр зүтгэлийг үнэлэн төрийн дээд одон, медаль болон салбарын шагналаар шагнуулахаар тодорхойлон холбогдох байгууллагад материалыг хүргүүлж 62 ажилтан төрийн дээд цол, одон медалиар, 149 ажилтан салбар яамдын шагналаар шагнагдсан бөгөөд мөн тус байгууллагад он удаан жил ажилласан 50 ажилтныг “Монголросцветмет” ТӨҮГ-ын, 15 ажилтныг “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын шагналаар шагнасан байна.

Мөн холбогдох хууль журмын дагуу тэтгэвэрт гарсны урамшуулал 37 ажилтанд, буцалтгүй тусламж 68 ажилтанд, хүүхэд асрах чөлөөтэй 1 хүртэлх насны хүүхэдтэй 26 эхэд тэтгэмж тус тус олгосон байна.

## 5.3. Сургалт, хөгжил

Үйлдвэрийн газар нь 2025 онд сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажилтнуудыг ХАБЭА-н ээлжит давтан сургалт, эрх сунгах давтан сургалт, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх, мэргэжлийн зэрэг ахиулах зэрэг 5 төрлийн 90 сургалтад давхардсан тоогоор 6040 ажилтныг хамруулсан.

Үүнээс гадна “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь 2020-2025 оны дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөө, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн бодлого, үйлдвэрүүдийн шаардлагатай ажлын байр, орон тооны захиалга, хэрэгцээнд үндэслэн шинэ залуу боловсон хүчин, үе дамжсан залгамж халаа уурхайчдыг бэлтгэх, Зүүн цагаан дэлийн далд уурхай болон цаашдын ашиглалтад оруулахаар төлөвлөж буй Өргөний ил уурхай, Баяжуулах фабрик, төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжингийн үйлдвэр гэх мэт бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийг хэрэгжихэд шаардлагатай инженер техникийн ажилтнууд, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх ажлын хүрээнд ОХУ-ын Эрхүүгийн Үндэсний судалгааны техникийн их сургуульд /ИРННТУ/ (манай техник, тоног төхөөрөмжийн ихэнх нь орос улсынх байдаг) оюутан суралцуулах талаар санал солилцон, санамж бичгийг байгуулж 2020 оноос ТӨҮГ-ын зардлаар өөрийн ажилчдын 10 хүүхдийг дараах 6 мэргэжлээр сургалтын төлбөрийг хариуцан суралцуулснаас 2024 онд 1 оюутан хими технологийн инженер мэргэжлээр төгсөж “Бор-Өндөр” УБҮ-т ажиллаж байна. Дээрх оюутнуудын суралцаж буй мэргэжил:

- Уулын цахилгаанжуулалт, автоматжуулалтын инженер
- Уулын машин, тоног төхөөрөмжийн инженер
- Маркшейдер инженер
- Далд уурхайн ашиглалтын инженер
- Баяжуулагч инженер
- Хими технологийн инженер.

Мөн 2025 – 2026 оны хичээлийн жилээс ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр ТӨҮГ-ын нэр дээр ОХУ-ын Эрхүүгийн Үндэсний судалгааны техникийн их сургуульд (ИРННТУ) уул уурхайн буюу уулын цахилгаанжуулалт, автоматжуулалтын инженер, маркшейдер инженер, далд уурхайн ашиглалтын инженер мэргэжлээр 5 оюутныг сургаж эхлээд байна.

## 6. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ /ХАБЭА/-Н ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### 5.4. Сахилга хариуцлага

Тайлант хугацаанд хөдөлмөрийн сахилга, дотоод дүрэм, журам зөрчсөн зэрэг асуудлаар холбогдох баримт, хууль, дүрэм, журмыг үндэслэн нийт 265 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан байна.

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь үйл ажиллагаандаа “Нэн түрүүнд-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” гэсэн суурь зарчмыг баримтлан Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, ТӨҮГ –ын “Хөдөлмөр хамгаалал удирдлагын систем”-ийг удирдлага болгон Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO45001:2018 стандартад нийцсэн үйл ажиллагаа эрхлэх бодлого баримтлан ажиллаж байна.

### 6.1. ХАБЭА-н чиглэлээр авч хэрэгжүүлсэн төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл

ТӨҮГ-ын харьяа “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэр /цаашид УБҮ гэх/ 2025 оны жилийн эцсийн байдлаар ХАБЭА-н удирдлага зохион байгуулалтыг сайжруулах – 14, ХАБЭА-н сургалтаар ажилчдын аюулгүй үйлдвэрлэл явуулах зан үйлийг бий болгох -8, Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах аюулгүй ажлын орчин бий болгох-10, Техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангах-9, Гал болон гамшиг ослын бэлэн байдлыг хангах-7, ISO стандарт нэвтрүүлэх зорилтын хүрээнд 4-н ажлыг үндсэн 6 чиглэлээр нийт 52 нэр төрлийн ажил төлөвлөн гүйцэтгэхээс нийт 49 нэр төрлийн ажлыг зохион байгуулан 94%-н гүйцэтгэлтэй ажилласан байна. ХАБЭА-н төлөвлөгөөнд тусгагдсан гүйцэтгэл дутуу ажлыг 2026 оны төлөвлөгөөнд дахин тусгаж хэрэгжүүлэн ажиллана.

ТӨҮГ-ын харьяа “Шижир-Алт” алтны үйлдвэр /цаашид АҮ гэх/ 2025 оны жилийн эцсийн байдлаар ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд-1, Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах хүрээнд-2, Дотоод хяналт шалгалтын хүрээнд-1, Ажиллагсдыг чадваржуулах, ХАБЭА-н сургалт зохион байгуулах ажлын хүрээнд-2 нийт 6 нэр төрлийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2025 онд ХАБЭА-н зөрчлөөс шалтгаалан үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа тасалдсан, доголдсон сул зогсолтын цаг бүртгэгдээгүй болно.

### 6.2. ХАБЭА-н зохион байгуулалт, төлөвлөгөөт сургалт

ХАБЭА-н шинэ ажилтны сургалтыг 7 хоног бүр 2, 4 дэх өдрүүдэд зохион байгуулан ажиллаж 282 хүн сургалтад хамрагдав. Шилжин ажилласан 594 ажилтанд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллаа.

“Бор-Өндөр” УБҮ-ийн нийт ажилчдын ХАБЭА-н 12 цагийн сургалтыг 2025.05.12-ны өдрөөс эхлэн 2025.06.03 хүртэл ажлын 16 өдөр нийт 1290 ажилтан хамруулж эхний хагас жилийн шалгалтыг зохион байгуулан ажилсан байна.

ХАБЭА-н 12 цагийн 2025 оны 2 дугаар хагас жилийн сургалтыг 11-р сарын 24 өдрөөс 12-р сарын 10-ны хооронд ажиллагсдыг хамруулахаар зохион байгуулан УБҮ-ийн нийт 1228 ажилтан хамрагдсан.

Тайлант хугацаанд “Бор-Өндөр” УБҮ-ийн цех, нэгжүүдийн захиалгыг үндэслэн шаардлагатай ажиллах хүчний нөөц бэлтгэх, мэргэшүүлэх, шинээр ажилд орж буй ажилтныг чиглүүлэх хөтөлбөрт хамруулан мэргэжлийн чиг баримжаа олгох, нийт ажиллагсдын ур чадвар, дадлыг сайжруулах, мэдлэгийг сэргээх, бататгах зорилгоор:

- Давтан сургалт – 2976 ажилтан
- Төлөвлөгөөт сургалт – 630 ажилтан
- Төлөвлөгөөт бус сургалт – 1117 ажилтан
- Мэргэшүүлэх сургалт - 111 ажилтан
- Мэргэжлийн зэрэг нэмэгдүүлсэн - 106 ажилтан
- Шинэ мэргэжил, шинэ эрх- 80 ажилтан
- Шалгалт өгсөн - 3454 ажилтан

2025 оны байдлаар нийт 876 ажилтанд ХАБЭА-н урьдчилсан зааварчилага өгч, ажлын байрны тодорхойлолт танилцуулсан бөгөөд үүнээс шинээр ажилд орж байгаа 282 ажилтан, өөр ажлын байр болон албан тушаалд шилжин ажилласан 594 ажилтан байв. Давхардсан тоогоор нийт 9350 ажилтанд сургалт зохион байгуулж, сургалтад хамруулан шалгалт авсан байна.

Бор-Өндөр МБС-ийн 55 суралцагч, ШУТИС-УУГС-ийн маркшейдер болон УУАшиглалтын инженерийн 36 оюутан, 1 багш, бусад сургуулийн 3 оюутан үйлдвэрлэлийн дадлага, ШУТИС-УУГС-ийн УУМТТ-ийн инженерийн 9 оюутан, үйлдвэртэй танилцах дадлага тус тус хийсэн. Мөн Эрдэнэт ШУТИС-ийн баяжуулалтын технологич инженерийн төгсөх курсын 1 оюутан дипломын ажлын өмнөх дадлага, ОХУ-ын Эрхүү хотын Уул уурхайн сургуульд Эрдэнэс Критикал Минралс ТӨҮГ-ын гэрээтэй 8 оюутан, Говьсүмбэр ПТК-ийн ХММ-ын ангийн 2 суралцагч нийт 20 оюутан, суралцагч нар мэргэжлийн дагуу УБҮ-ийн цех, хэсгүүдэд үйлдвэрлэлийн уртын дадлагыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

### **6.3. ХАБЭА-д зарцуулсан зардлын биелэлт**

- 2025 оны жилийн эцсийн байдлаар нэг ажилтанд 2,391,347 төгрөгийг ХАБЭА-н чиглэлээр зарцуулахаар төлөвлөсөн ба үүнээс аюулгүй ажиллагааны сургалт, хамгаалах хэрэгсэл, ажлын хувцас, хор саармагжуулах үйлчилгээтэй хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хангах болон ХАБЭА-н аян зохион байгуулах, эм, тариагаар хангах, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, гэнэтийн ослын даатгалд хамруулах, аюулыг мэдээлэлсний урамшуулал олгох хийлгэх чиглэлээр 1 ажилтанд 1,374,802 төгрөгийг зарцуулан ажилласан байна. Энэ нь үйлдвэрлэлийн нийт зардлын 0.88% болж байна. Цаашид ХАБЭА-н тухай хуулийн 26.2 дахь заалтын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус төлөвлөн зарцуулах шаардлагатай байна.

- 2025 онд ажилтан бүрт шаардлагатай
  - 5 төрлийн тусгай зориулалтын ажлын хувцас
  - 2 төрлийн ажлын цамц
  - 3 төрлийн тусгай зориулалтын ажлын гутал
  - 10 төрлийн хамгаалах хэрэгсэлээр ханган ажилласан байна.Тайлангийн улиралд нийт 1525 ажилтныг гэнэтийн ослын даатгалд хамруулсан байна.

#### **6.4. ХАБЭА-н зөрчил, аюулыг илрүүлж урамшуулсан талаар мэдээлэл**

- 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт ажилтнуудаас ХАБЭА-н хууль, аюулгүй ажиллагааны дүрэм журам зөрчигдсөн 5 зөрчил бүртгэгдэж зөрчлийн мөрөөр нийт 46 ажилтанд хөдөлмөрийн тухай хууль, дотоод журмын дагуу хариуцлага тооцож арга хэмжээ авсан байна.
- 2025 онд нийт 211 ажилтан 1576 аюулыг мэдээлэх хуудсыг ашиглан аюулыг илрүүлж устгах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан ба ХАБЭА-н үйл ажиллагаанд идэвхи санаачилгатай оролцсон 211 ажилтнуудад журмын дагуу нийт 15,801,360 төгрөгийн урамшууллыг олгосон байна. Тухайн үзүүлэлтийг 2024 онтой харьцуулахад 33% өссөн байна.

#### **6.5. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого болон осолд дөхсөн тохиолдлын талаар мэдээлэл**

- 2025 онд үйлдвэрийн газрын харъяа “Бор-Өндөр” УБҮ дээр 3 үйлдвэрлэлийн осол 6 осолд дөхсөн тохиолдол бүртгэгдсэн болно. Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэж актыг улсын байцаагчаар баталгаажуулсан бөгөөд осолд дөхсөн тохиолдлоос үүдэлтэй ажилтан бэртгэж гэмтээгүй бөгөөд давтан осол гарахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажлын байрны эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийж үнэлсэн болно. Тухайн үзүүлэлтийг 2024 онтой харьцуулахад үйлдвэрлэлийн ослын тоо 57% буурсан байгаа бол осолд дөхсөн тохиолдлын хувьд 16% өссөн байна.
- 2025 онд “Шижир-Алт” АҮ-т үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн тохиолдол бүртгэгдээгүй болно.

#### **6.6. Хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, мэргэжлээс шалтгаалах өвчинд хяналт тавих, эмч, эрүүл ахуйн хяналт**

- 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 25-ны өдрийг хүртэл хугацаанд ХАБЭМТөвийн мэргэжлээс шалтгаалах өвчний эмч нартай хамтран “Бор-Өндөр” УБҮ-т 4-с дээш жил ажилласан 800 ажилтныг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулсан байна.
- 2025 онд “Бор-Өндөр” УБҮ-ийн ХАБЭМТөвд үзүүлэх ажилтнуудыг илгээж нийт 15 ажилтан мэргэжлээс шалтгаалах өвчний групп тогтоолгосон бол 1 ажилтан ердийн групп тогтоолгосон байна.
- 2025 онд “Бор-Өндөр” УБҮ-ийн эмнэлэгийн хэсэг нийт 1654 ажилтанд үзлэг хийж, шинээр ажилд орсон 282 ажилтныг сумын нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэг хамруулж “Осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж”-ийн зааварчилгааг өгч ажилласан байна.
- 2025 оны 04.01-05.01-ний хугацаанд давхардсан тоогоор нийт 1780 ажилтны артерын даралтыг үзэж 65 ажилтныг А/Д 1-2-р зэргийн ихсэлттэй гэдгийг тогтоон хяналтанд авч ажилласан бол 2025 оны 10.29-12.31-ний хугацаанд давхардсан

тоогоор нийт 1733 ажилтны артерын даралтыг үзэж 51ажилтныг А/Д 1-2-р зэргийн ихсэлттэй гэдгийг тогтоон хяналтанд авч ажилласан байна.

#### **6.7. ХАБЭА хяналт, шалгалт**

- “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO45001:2018 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж баталгаажуулсан байгууллага бөгөөд гадны мэргэжлийн байгууллага 2025 оны 02 дугаар сард стандартын 1-р магадлан аудитын шалгалтыг үйлдвэрий газрын хэмжээнд зохион байгуулж ХАБЭА-н чиглэлээр үл тохирол илрээгүй болно.
- “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл-ахуйн бодлогын баримт бичиг “Хөдөлмөр Хамгааллын Удирдлагын Систем”-д заасан чиг үүргийн дагуу Аюулгүй Ажиллагааны I шатны үзлэгийг ээлж бүр наряд-даалгавар өгдөг анхан шатны Инженер Техникийн Ажилтнууд, II шатны үзлэгийг долоо хоног бүр хэсэг, албадын дарга, удирдах ИТА, III шатны үзлэгийг сард 2 удаа цехийн удирдлагын түвшинд, IV шатны үзлэгийг тухайн үйлдвэрийн ерөнхий мэргэжилтнүүд сард 1-ээс доошгүй удаа төв захиргаанаас томилогдсон ажлын хэсэг хагас жилд 1-ээс доошгүй удаа тус тус шалгалт явуулж зохих акт, шаардлага, зөвлөмжийг өгч гүйцэтгэлд хяналт тавьж ажилладаг болно.
- 2025 онд ХАБЭА-н 4 дүгээр шатны үзлэгийг 11 удаа зохион байгуулсан байна.
- 2025 онд ТӨҮГ-ын захиргаанаас ХАБЭА-н ээлжит үзлэг шалгалт хийх ажлын хэсэг томилогдон “Бор-Өндөр” УБҮ-т 2 удаа, “Шижир-Алт” АҮ-т 1 удаа тус тус ХАБЭА-н нөхцөл байдалд үзлэг шалгалт хийн зөрчлийг арилгуулж ажилласан байна.
- 2025 онд УБҮ-ийн ХАБЭА-н зөвлөлийн хурлыг 18 удаа зохион байгуулж ХАБЭА-н асуудлыг авч хэлэлцэн шийдвэрийг протоколоор баталгаажуулан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

#### **6.8. ХАБЭА нөлөөллийн ажил болон бусад**

- 2025 оны дэлхийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн өдрийг тохиолдуулан УБҮ-ийн хэмжээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аян”-г 2025 оны 04 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 10-г “Бор-Өндөр” УБҮ-ийн хэмжээнд зохион байгуулан ажиллаа. Уг аяны хүрээнд “Хандлагаа өөрчилж хариуцлагатай ажиллая” сэдэвт 2 цагийн сургалт 2025.04.10,11-ний өдрүүдэд Бор-Өндөр сумын соёлын төвд орон нутгийн цагдаагийн хэлтэс, онцгой байдлын алба, нийгмийн даатгалын тасагтай хамтран зохион байгуулж уг сургалтад 600 гаран ажилтанг хамруулсан. Мөн “Happiness core” ХХК-с мэргэжлийн сэтгэл судлаач З.Уянга-г урьж авчран “Эерэг сэдэлжүүлэх лекц” сэдэвт 2 цагийн сургалтыг 2025.04.24,25-ны өдрүүдэд 600 ажилтан хамруулан зохион байгууллаа. Цех хэсгүүдийн дунд хөгжөөнт дэвжээ тэмцээнийг 5 төрөлт байдлаар зохион байгуулж 3 байр шалгаруулан 1-р байр 1,000,000 төгрөг, 2-р байр 800.000 төгрөг, 3-р байрд 600.000 төгрөг тус бүр шагнал урамшуулал олгож ажиллаа. Мөн “Галын аюулгүй ажиллагаа” сургалтыг 2025.04.23-ны өдөр Бор-Өндөр сумын Онцгой байдлын албатай хамтран цех хэсэг бүрээс 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр УБҮ-ийн Нефть базад галын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж сургалт дадлага хийж ажиллаа.
- 2025.04.28-ны өдөр холбогдох журмын дагуу үйлдвэрлэлийн ослоор амь насаа алдсан хүмүүсийн ар гэрт мөнгөн тэтгэмж олгосон болно.
- “SCS” ХХК-тай хамтран “Бор-Өндөр” УБҮ-т аюулгүй ажиллагааны цахим зааварчилгааны системийг нэвтрүүлэн ба уг системээр дата үүсгэн цахим бүртгэл хийдэг болж зарим ажлыг хөнгөвчилсэн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/22 тушаалаар УБҮ-н хэмжээнд “Хандлагаа өөрчилж хариуцлагатай ажиллая” хөтөлбөрт аян 2025 оны 06-р сарын 30 хүртэл зохион байгуулагдаж нийт ажилчдыг ХАБЭА-н зөв хандлага, эерэг өөрчлөлтөд уриалах, бусдад зөв үлгэр жишээ, хариуцлагатай хамт олныг бий болгох, шинэ санал санаачилга дэвшүүлэх, бүтээлч ажиллах боломжийг бий болгоход чиглэсэн ажлууд хийгдсэн болно. Аяны хүрээнд “Өглөөний ХАБ” уриан дор ажилчид наряд, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөхдөө шинэлэг, өвөрмөц байдлаар бусдадаа шинэ мэдээлэл хүргэх аюулгүй ажиллагааны дүрмийг тайлбарлах байдлаар ХАБЭА-н тухай ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах нь ажилчдын оролцоог харуулсан. Цех, хэсгийн дарга нарын манлайллыг ажлын байрны гэрэлтүүлгийг стандарт түвшинд болгох гэрэлтүүлэг сайжруулах ажлын зохион байгуулалтаар оролцоог харна. Мөн уг аяны хүрээнд цех, хэсгүүдийн галын булан, сарааг нэг стандартад аваачих зэрэг зорилтод ажлуудыг төлөвлөн гүйцэтгэлд хяналт тавин ажиллаа. Дээрх аяны хүрээнд хийж хэрэгжүүлсэн мэдээлэл бүрийг фото зургаар нийт ажилтнуудын “НЭН ТҮРҮҮНД ХАБЭА” фэйсбүүк группт тухай бүр нийтэлж байсан болно.

## 7. БАЙГАЛЬ ОРЧИН, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ

### “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын ХАБЭА 2025 оны жилийн эцсийн статистик мэдээлэл

1. “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-т 3 дугаар улирлын байдлаар нийт 1634 ажилтан ажиллаж байна.



Ажилтан: 1300

ИТА: 202

Албан хаагч: 132

2. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар:



3. Хэвийн болон хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилтны тоо:

Хэвийн: 338      Хэвийн бус: 1296



4. Ажилтан бүрт



5 төрлийн тусгай зориулалтын ажлын хувцас  
2 төрлийн ажлын цамц  
3 төрлийн тусгай зориулалтын ажлын гутал  
10 төрлийн хамгаалах хэрэгсэл олгож байна.

5. 2025 оны турш давхардсан тоогоор нийт 1654 ажилтанд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж ажилласан байна.



6. Нэг ажилтанд зарцуулж буй ХАБЭА жилийн эцсийн зардлын хэмжээ 1,374,802 төгрөг байна.



₮1,328,106

7. Үйлдвэрлэлийн нийт зардлын төсөвт ХАБЭА зардлын эзлэх хувь 0,88% байна.



8. Гэнэтийн ослын даатгалд хамруулсан ажилтны тоо: Нийт 1525 ажилтныг гэнэтийн ослын даатгалд хамруулсан байна. Нийт ажилтны даатгалын үнэлгээ 108,290,000,000 төгрөг байна.



₮108,290,000,000

9. Ажилтан тус бүрт ноогдох урьдчилан сэргийлэх үзлэг, эмнэлэгийн үйлчилгээний зардалд 145,000 төгрөг төлөвлөсөн байна.




₮145,000

10. 2025 онд 2 удаа ХАБЭА-н 12 цагийн хичээл сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 2,518 ажилтан сургалтанд хамрагдсан байна.



3454

11. 2025 онд нийт 211 ажилтнуудаас 1654 гаруй аюулын талаарх мэдээлэл хүлээн авч аюулыг устган 15,801,360 төгрөгний урамшуулал олгосон байна.



## 7.1. Байгаль орчны үнэлгээ, зөвшөөрөл, төслийн хэрэгжилтийн хүрээнд

- Төв аймгийн Заамар сум дахь MV-022859 тоот тусгай зөвшөөрөлтэй Хашаат, Овоот, Даваатын алтны шороон ордын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. Үүний үндсэн дээр байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж, төслийн үйл ажиллагааг эхлүүлсэн байна.
- Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын MV-000174 тоот тусгай зөвшөөрөлтэй Бор-Өндөрийн жоншны далд уурхайн төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлэн болгож илгээсэн.
- Хэнтий аймгийн Дархан сумын MV-016657 тоот тусгай зөвшөөрөлтэй Баргилтын төмрийн хүдрийн ордын шинэчилсэн байгаль орчны нарийвчилсан үнэлгээг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.
- “Зүүн цагаан дэлийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдөр батлуулсан.
- “Туулын полигон алтны шороон ордыг драгаар ашигласан хэсгийн алтны үүсмэл ордын төслийн байгал орчны менежментийн төлөвлөгөөг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр батлуулсан.
- "Баргилтын төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах" төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр батлуулсан.
- Дорноговь аймгийн Өргөн сумын MV-012884 тоот тусгай зөвшөөрөлтэй Өргөний 9-р хүдрийн бүс талбайн байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтийг 2025 оны 08 дугаар сарын 19-нд гаргуулсан.
- Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт хэрэгжүүлж буй MV-000174 тоот тусгай зөвшөөрөлтэй “Адаг, Бор-Өндөрийн далд уурхай ба уулын баяжуулах үйлдвэр”, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт хэрэгжүүлж буй “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэрийн “Дулааны цахилгаан станц”, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт хэрэгжүүлж буй Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэрийн “Баяжуулах үйлдвэр” төслийн байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулахаар бичиг баримтыг бүрдүүлэн илгээгээд байна.
- MV-022859 тоот тусгай зөвшөөрөлтэй Хашаат, Овоот, Даваатын алтны шороон ордын усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн E-2504-000441, MV-016657 тоот тусгай зөвшөөрөлтэй Баргилтын төмрийн хүдрийг ордыг ил аргаар ашиглах, баяжуулах үйлдвэрийн төслийн усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн E-2504-000430 дугаартай гарсан байна.
- MV-000175 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Туул голын голдирол” нэртэй алтны шороон ордын E-2507-000128 тоот ус ашиглуулах дүгнэлт 2025 оны 08 дугаарсарын 19-ны өдөр гаргуулав.

## 7.2. Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд:

Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд байрлах MV-000174 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 0.16 га талбайд 6,163 м<sup>3</sup> дүүргэлт хийхээр төлөвлөснөөс 2025 онд 0.12 га талбайд 2,518 м<sup>3</sup> дүүргэлтийн ажлыг хийж

## 8. ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОН ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

гүйцэтгэсэн байна. MV-022859 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хашаат, Овоот, Даваатын алтны шороон ордын талбайд техникийн нөхөн сэргээлтийг 17.35 га, биологийн нөхөн сэргээлтийг 6.85 га, түүнчлэн дүйцүүлэн хамгаалах хэлбэрээр 10 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн болно. MV-000175 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Туул голын голдирлын талбайд техникийн нөхөн сэргээлтийг 14.35 га, биологийн нөхөн сэргээлтийг 6.85 га, мөн дүйцүүлэн хамгаалах чиглэлээр 5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 95 дугаар тогтоолоор “Монголросцветмет” ТӨҮГ-ын нэрийг “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ болгон өөрчилсөнтэй холбоотойгоор, Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэрийн эзэмшил болон ашиглалтын 54 ширхэг газрын гэрчилгээний нэрийг шинэчилж, шинээр бүртгүүлэх ажлыг зохион байгуулан ажиллав. 2025 оны 7 дугаар сард газрын төлбөрийг бүрэн төлж, шийдвэрлэсэн. Мөн үйлдвэрийн эзэмшил, ашиглалтын 44 газарт газрын төлөв байдал, улсын чанарын хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгүүлэн баталгаажуулсан байна.

### 7.3. Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд:

- Булган аймгийн Бүрэгхангай сумын засаг даргатай “Байгаль орчныг хамгаалах, Уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” нийгмийн хариуцлагын гэрээг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан.
- Бүрэгхангай сумын Байгаль орчны улсын байцаагчтай “Хог хаягдлын” гэрээг 2025 оны 07 дугаар сарын 01-ны өдөр байгуулсан.
- Увс аймгийн Наранбулаг сумтай хамтран ажиллах гэрээг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр байгуулан баталгаажуулаад байна.

### 7.4. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд:

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр 2 сая мод тарьж ургуулах, цаашид арчлан хамгаалах амлалт авч, хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү амлалтын хүрээнд 2025 онд нийт 72,500 ширхэг модыг шинээр тарьсан бөгөөд тэдгээрийг байршлаар нь авч үзвэл Өвөрхангай аймгийн Хархорин суманд (“Хархорум” хот) 15,000 ширхэг, Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд 32,500 ширхэг, Хэнтий аймгийн Бэрх суманд 10,000 ширхэг, Дундговь аймагт 8,000 ширхэг, Дорноговь аймгийн Иххэт суманд 5,000 ширхэг мод тус тус тарьсан байна. Тарьсан модны зүйлийн хувьд ихэвчлэн хайлаас, улиас, агч мод зонхилсон болно.

Монгол Улсын эдийн засаг нь уул уурхай, эрдсийн түүхий эдийн эрэлт, үнийн нөлөөллөөс хэт хамааралтай байна. Уул уурхайн орлогоос тодорхой хувийг төвлөрүүлэн баялгийн сан байгуулж, уул уурхайн бус салбар болон нийгмийн салбарыг хөгжүүлэх, томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, менежментийг сайжруулах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах орчныг бүрдүүлэх шаардлага тулгарч буйг төр засгийн төвшинд анхааран ажиллаж байна.

Жонш, алтны олборлолт, жоншны баяжмал үйлдвэрлэлийн үндсэн чиглэлтэй анх байгуулагдсан “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь улс орны эдийн засаг, нийгэм, соёл, ахуйн олон асуудлыг улс, орон нутгийн хэмжээнд шийдвэрлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан. Монгол улсын анхны гадаадын хөрөнгө оруулалттай, уул уурхайн ууган үйлдвэрүүдийн нэг бөгөөд стратегийн ач холбогдол бүхий экспортын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг дэлхийд данстай томоохон үйлдвэр болон хөгжиж ирсэн.

2013 оноос жоншны дэлхийн зах зээлийн уналт, “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын жоншны бүтээгдэхүүний эрэлт, борлуулалт эрс буурсан зэрэг нөхцөл байдлаас үүдэн үйлдвэрийн газрын санхүү-эдийн засгийн байдал хүндэрч, жоншны үйлдвэрлэлийн хүчин чадлаа 70-75%-иар бууруулах бодит шаардлагатай тулгарсан. Хайлуур жоншны баяжмалын экспортыг сэргээхийн тулд “Бор-Өндөр” УБҮ-ийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг бүрэн ашиглах, мөн үйлдвэрлэлийн шаардлагыг хангахуйц жоншны хүдрээр хангах, эрчим хүчний хэмнэлт гаргахын тулд шинээр эрчим хүчний эх үүсгэвэр гаргах, зах зээлд өрсөлдөхүйц шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйл ажиллагааны зардлыг хэмнэхийн тулд үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэх шаардлага урган гарч байгаа юм.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөний 11-т заасны дагуу Гангийн цогцолборыг ашиглалтад оруулна.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2024-2028 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөний Нэгдлийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд Үйлдвэрлэл технологийн парк болон бусад боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулна.

Дээрх болон холбогдох бусад тогтоол шийдвэрийн дагуу олон улсын зах зээлд жонш болон төмрийн хүдрийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн аюулгүй, тогтвортой, нээлттэй, хариуцлагатай уул уурхай, үйлдвэрлэл, шинээр ажлын байр бий болгох, улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах “Уул уурхай - Дэд бүтэц - Аж үйлдвэрлэл”-ийн тэргүүлэгч компани болж хөгжих зорилготой ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Зүүн цагаан дэл”-ийн далд уурхайн төслийг 2022 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Мөн төмрийн хүдрийн чиглэлээр нойтон баяжуулах үйлдвэр, хорголжингийн үйлдвэр, цайр агуулсан төмрийн хүдрийг баяжуулж, цайр ялгаж авах, эрчим хүчний чиглэлээр “Бор-Өндөр” УБҮ-ийн дулааны станцыг цахилгаан станц болгох зэрэг төслүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.

### 1.1. “Бор-Өндөр” УБҮ-ийн Дулааны станцыг цахилгаан станц болгон өргөтгөх төсөл:

“Бор-Өндөр” УБҮ нь өвлийн улирлын оргил ачааллын үед 9.0 МВт суурилагдсан хүчин чадалтай бөгөөд сард дунджаар 3.5 сая кВт.цаг буюу 1.3 тэрбум орчим төгрөгийн цахилгаан эрчим хүч хэрэглэж байна. Эрчим хүчний хэрэглээ тасралтгүй өсөн нэмэгдэж, бүс нутгийн хэмжээнд хомсдол үүсэж байгаатай холбогдуулан эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг сайжруулах, гаднаас хараат байдлыг бууруулах, “Бор-Өндөр” ҮТП-ийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг тогтвортой эрчим хүчээр хангах зорилгоор “Бор-Өндөр” УБҮ-ийн дулааны станцыг цахилгаан станц болгон өргөтгөх төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.



#### Төслийн явц:

- Төсөл хэрэгжүүлэх газар нь “Бор-Өндөр” УБҮ-ийн талбайд, дулааны станцын дэргэд байршина.
- 12МВт дулааны цахилгаан станцын ТЭЗҮ батлагдсан.
- Нүүрс буулгах, хадгалах талбай шинээр байгуулах шаардлагагүй, одоо ашиглаж буй талбайг ашиглах.
- Дулааны цахилгаан станцын ерөнхий зураг төсөл боловсруулагдаж байна.

### 1.2. Төмрийн баяжмалыг хорголжлох үйлдвэр төсөл

“Бор-Өндөр” УБҮ-ийн нойтон соронзон аргаар баяжуулсан төмрийн хүдрийн баяжмалыг хорголжлон нэмүү өртөг шингээх, экспортын шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, улмаар дотоодын металлургийн үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах зорилготой. Тус үйлдвэр нь жилд 200.0 мянган тонн хорголж үйлдвэрлэх хүчин чадалтай.

#### Төслийн явц:

- Хорголжин үйлдвэрлэх технологи туршилт, шинжилгээний ажлыг ШУТИС-ийн Механик Тээврийн Сургуулийн цутгуурын лабораторид стандарт болон чанарын шаардлага хангаж байгааг судалгааны үр дүнгээр баталгаажсан.
- Үйлдвэр баригдах 27 га газрыг гэрчилгээжүүлэн авсан.
- Хорголжин үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулагдан батлагдсан.
- Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийгдэж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийгдсэн.
- Үйлдвэрлэлийн технологийн туршилтын үр дүнд суурилан технологийн зураг хийлгэх.

### 1.3. Төмрийн хүдрийг нойтон аргаар баяжуулах үйлдвэр байгуулах төсөл

Баргилтын төмрийн хүдрийн уурхайн хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулан Fe-65 хувийн агуулгатай баяжмал жилд 300 мян.тн үйлдвэрлэхээр төлөвлөж байна. Энэхүү үйлдвэрлэл нь хүдрийн боловсруулалтын түвшинг

дээшлүүлэх, илүү нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргах, үйлдвэрийн үр ашиг, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Ингэснээр шинээр байгуулагдах хорголжлох үйлдвэрийг стандартын түүхий эдээр тасралтгүй хангах боломж бүрдэнэ.

#### **Төслийн явц:**

- Баргилт ордын скарн-магнетитын хүдрийн баяжуулалтын судалгааг “Бигом Чойр” ХХК-ийн баяжуулах үйлдвэрт хийгдсэн.
- Үйлдвэр баригдах 27 га газар шийдвэрлэгдсэн.
- Дэд бүтцийн тооцоолол хийсэн.
- “Нойтон баяжуулах үйлдвэр”-ийн ТЭЗҮ, зураг төсвийн ажлын гэрээг “Шинжлэх ухааны паркийн захиргаа”-тай байгуулсан. Баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулагдан батлагдсан.

#### **1.4. Хайлуурын хүчил боловсруулах төсөл**

“Бор-Өндөр” УБҮ-ийн хайлуур жоншны нөөцөд түшиглэн жоншийг гүн боловсруулж, дотоодын химийн үйлдвэрлэл, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр Бор-Өндөр ҮТП-ийг байгуулж, жоншны 97 хувийн баяжмал, фторт устөрөгч, фторт хөнгөн цагаан, фторт бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хайлуур жоншны бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин нэмэгдүүлж нэмүү өртөг шингэсэн, шинэлэг, зах зээлд эрэлттэй, өрсөлдөхүйц бүтээгдэхүүнийг шинэ дэвшилтэт техник технологи бүхий загвар химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтой.

Бор-Өндөр ҮТП-ийн хүрээнд хайлуур жоншны баяжмалыг боловсруулан фторт нэгдлүүдийг гарган авснаар жоншны салбарт бизнесийн орчин сайжирч, бүтээгдэхүүний нэр төрөл, өрсөлдөх чадвар, худалдааны эргэлт нэмэгдэн, фторын хүчил, фторт хөнгөн цагаан үйлдвэрлэгч, экспортлогч улс болно.

2013 оноос эхэлсэн жоншны дэлхийн зах зээлийн уналт, 2022 оны ОХУ, Украйны мөргөлдөөнөөс шалтгаалан “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын жоншны бүтээгдэхүүний эрэлт, борлуулалт эрс буурсан, Зах зээлд өрсөлдөхүйц шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд жоншийг дахин боловсруулж технологийн дараагийн шатанд гаргах зайлшгүй шаардлага тулгарч байна.

#### **Төслийн явц:**

- Хайлуур жоншны баяжмалаас хайлуурын хүчил гарган авах ТЭЗҮ /1-р үе шат/-ний урьдчилсан суурь судалгаа, туршилтын гэрээг “Шинжлэх ухааны паркийн захиргаа”-тай байгуулсан.
- БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Өвөр Монголын Хятад Монголын технологи дамжуулах төв”-д хайлуур жоншны баяжмалаас хайлуурын хүчил үйлдвэрлэх боломжийг судлах технологийн туршилт, судалгаа хийлгэхээр хайлуур жоншны баяжмалын дээж хүргүүлж туршилтын ажил эхлүүлэх гэж байна.

#### **1.5. Хайлуурын жоншны баяжмал ФФ-97 үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл**

Төслийн зорилго нь Монгол Улсын ашигт малтмалын боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, илүү нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, үйлдвэрийн бүтээгдэхүүний өртөг бууруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд оршино.

Бүтээгдэхүүний чанарыг өсгөн ФФ-97 маркийн баяжмалыг үйлдвэрлэх, цаашид химийн үйлдвэрүүдийн түүхий эд болох фторт устөрөгч, криолит зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх суурь нөхцөлийг хангана.

**Төслийн явц:**


- Бор-Өндөр ҮТП-ийн хүрээнд “Эрдэнэс ҮТП” ХХК-тай хамтын ажиллагаа, зорилгыг уялдуулахын тулд ФФ-97 маркийн хайлуур жонш үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулагдан батлагдсан.
- Төслийн төлөвлөлтийн болон үнэлгээний бичиг баримтыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-д танилцуулан, “Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр” барих төслийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын ажил хийгдэж байна.

## 9. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь Монгол Улсын “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийн хүрээнд нийгмийн хариуцлагын үйл ажиллагааг явуулж байна.

### 9.1. Нийгмийн хариуцлагын ажлын хүрээнд хэрэгжүүлж буй төслүүд

- “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь Нийслэлийн Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт 160 айлын орон сууцыг орчин үеийн стандарт бүхий иж бүрэн спорт цогцолборын хамт барьж дуусгасан бөгөөд 2024 оны 02 дугаар сард улсын комисст хүлээлгэн өгч хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэр, Шижир-Алт алтны үйлдвэр болон захиргааны ажиллагсад нийт 160 айлыг орон сууцжуулсан.



- “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын “Уурхайчин” спорт цогцолбор нь 2024 оны 02 дугаар сард ашиглалтад орсон бөгөөд олон улсын стандартын дагуу баригдсан орчин үеийн спорт комплекс юм. Тус спорт цогцолборын дэргэд үйл ажиллагаа явуулж байгаа “Уурхайчин” волейболын клуб нь 2024-2025 оны волейболын дээд лигийн эмэгтэй төрөлд амжилттай оролцож IV байранд орсон. “Уурхайчин” клубийн тамирчдын бүрэлдэхүүнд 2025 оны байдлаар 3-н олон улсын хэмжээний мастер, хоёр спортын мастер тамирчин 2025-2026 оны дээд лигийн тэмцээнд оролцохоор бэлтгэл сургуулилт хийж байна. Мөн өсвөрийн тамирчид нас насны ангиллаар бэлтгэл бэлтгэл, сургуулилт хийж нэрэмжит тэмцээн, улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд тогтмол амжилттай оролцож байна.



- Ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх чийрэгжүүлэх зорилгоор фитнес зааланд 7 хоногт 4 удаа 3 цагаар дасгал хийх, спорт зааланд 7 хоногийн 2 удаа 3 цагаар спортоор хичээллэх хуваарь гаргаж бэлтгэл сургуулилт хийж байна



- Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа “Бор-Өндөр” УБҮ-ийн ажилчдыг байр орон сууцаар хангах зорилгоор “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-аас Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд 36 айлын орон сууцны барилгын дахин төлөвлөлтийг хийж 2025 оны байдлаар барилгын ажил 50 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн түүнчлэн “Бор-Өндөр” УБҮ-ийн инженер техникийн болон нарийн мэргэжлийн ажилчдыг орон сууцаар хангах зорилгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан 4 барилга болох 2295 м.кв 40 айлын 2 давхар бүхий 2 орон сууц, 769 м.кв талбай

бүхий 2 ширхэг 4 улирлын байруудыг балансаас балансад шилжүүлэн авч Бор-Өндөр суманд угсарч хүлээн аваад байна. Дээрх хоёр орон сууцны ажил дуусаж Бор-Өндөр УБҮ-ийн хэмжээнд нийт 90-100 инженер техникийн болон нарийн мэргэжлийн ажилчдын гэр бүл орон сууцаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

- “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь нийгмийн хариуцлагын хүрээнд ажилчдын хүүхдүүд болон 22-р хорооны хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах зорилгоор Нийслэлийн Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны нутаг дэвсгэр дээр шинээр баригдсан 160 айлын ажилчдын орон сууцны II блокийн 1 давхрын 330 м<sup>2</sup> талбайд Нийслэлийн Баянзүрх дүүргийн 128 дугаар цэцэрлэгтэй хамтарч байгууллагын дэргэдэх 4-н бүлэг бүхий салбар цэцэрлэг байгуулж цэцэрлэгийн насны 100 хүүхдийг хамруулсан. 2024 оны 02 дугаар сараас эхлэн үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд 2025 оны байдлаар байгууллагын ажилчдын 70-н хүүхэд, Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны 30-н хүүхэд сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамрагдаж байна.




- “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын зардлаар ОХУ-ын Эрхүү хотын Эрхүүгийн үндэсний судалгааны техникийн Их сургуульд 10 хүүхдийг уулын цахилгаанжуулалтын инженер, уулын машин тоног төхөөрөмжийн инженер, далд уурхайн ашиглалтын инженер, химийн технологийн инженер, баяжуулагч инженер, маркшейдер инженер гэсэн 6 мэргэжлээр сургаж 2025 оны эхний хасаг жилийн байдлаар нэг оюутан сургуулиа төгсөөд “Бор-Өндөр” УБҮ-т ажиллаж байна. Мөн 2025-2026 оны хичээлийн жилд ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр, “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын тодорхой хэмжээний зардлаар дахин 5-н хүүхдийг Эрхүүгийн үндэсний судалгааны техникийн Их сургуульд 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс суралцаж байна.

## 9.2. Орон нутгийн айл өрх, албан байгууллагыг ус, дулаан үйлдвэрлэлээр хангах үйл ажиллагаа

“Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газар нь нийгмийн хариуцлагын хүрээнд Хэнтий аймгийн Бор-Өндөр сум болон Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн Өгөөмөр тосгоны айл өрх, аж ахуй нэгжүүдийг хэрэглээний халуун, хүйтэн ус болон халаалт, дулаанаар ханган ажилладаг.

## 10. ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ГАРСАН ЗӨРЧИЛ, ХУУЛЬ ЭРХЗҮЙН МАРГААН, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ХИЙСЭН АЖИЛ, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь хууль, эрх зүйн хүрээнд өнгөрөгч 2025 онд дараах үндсэн чиглэлүүдээр ажиллалаа.



### 10.1. Шүүх, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн өмчит үйлдвэрийн газрын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх

Шүүх, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн өмчит үйлдвэрийн газрын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх ажлын чиглэлээр шүүхийн харьяалалтай 2 хэрэг, арбитрын харьяалалтай 5 хэрэг, Цагдаагийн байгууллагын 1 хэрэг буюу нийт 8 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон бөгөөд 7 хэрэгт хариуцагчаар, 1 хэрэгт хэрэг бүртгэлийн хэрэгт оролцогчоор оролцсон байна. Эдгээрээс 4 хэрэг эцэслэгдэн хянан шийдвэрлэгдсэн.

### 10.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох



- “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-ын хүсэлтээр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт иргэний шийдвэр гүйцэтгэх 5 ажиллагаа хийгдэж, 1 ажиллагаа дуусаж төлбөр барагдсан.
- “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-ын хүсэлтээр Хэнтий аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт иргэний шийдвэр гүйцэтгэх 1 ажиллагаа хийгдэж байгаа.
- “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-ын хүсэлтээр Говьсүмбэр аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт иргэний шийдвэр гүйцэтгэх 1 ажиллагаа хийгдэж дуусаж, төлбөр барагдсан.

- “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-ын хүсэлтээр БНХАУ-ын ӨМӨЗО-ны ардын анхан шатны шүүхэд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа амжилттай хийгдэж дууссан.
- “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-ын хүсэлтээр БНХАУ-ын Шанхай хотын шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ болон хуульд заасан бусад арга хэмжээг гүйцэтгүүлэн ажиллаж байна.

### 10.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

“Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ нь Монгол Улсын хууль тогтоомж, Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангах, мөн “Эрдэнэс Монгол” ХХК-аас өгсөн үүрэг, даалгаврыг үйл ажиллагаандаа тухай бүр хэрэгжүүлэн ажилласан.

- Тухайлбал, хууль тогтоомж болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийн талаарх тайлан, мэдээллийг 2025 онд “Эрдэнэс Монгол” ХХК-д нийт 3 удаагийн албан бичгээр хүргүүлэн тайлагнасан.
- ТӨҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан.
- Мөн Монгол Улсын Засгийн газрын холбогдох тогтоол, тэмдэглэл, албан даалгаврыг үйл ажиллагаандаа нийцүүлэн хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар “Эрдэнэс Монгол” ХХК-д тогтмол тайлагнан ажилласан.

### 10.4. Гэрээ байгуулах, бүртгэх, хэрэгжилтийг хангаж ажиллах

Гэрээний төсөл боловсруулах, хянах, төрийн өмчит үйлдвэрийн газарт мөрдөгдөж буй гэрээ байгуулах журамд заасан үүргийг хэрэгжүүлэх ажлын чиглэлээр 2025 онд нийт 667 гэрээ болон гэрээний төслийг хариуцсан нэгж ажилтантай хамтран боловсруулах, гэрээний төслийг хянах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан.

Үүнд:

- MRS-2025-01 дугаар 40, ECMS-2025-01 дугаар-133 /гадаад/ нийт 173 ш
- MRP-2025-02 дугаар 6, ECMP-2025-02 дугаар-83 /үйлдвэр/ нийт 89 ш
- MRP/MRS-2025-03 дугаар 28, ECMP-2025-03 дугаар 193 /дотоод/ нийт 221 ш
- MR-2025-04 дугаар 2, ECM-2025-04 дугаар 3 /хөлсөөр ажиллах/ нийт 5 ш
- MR-2025-05 дугаар 5, ECM-2025-05 дугаар 44 /ЗАА/ нийт 49 ш
- MR-2025-06 дугаар 6, ECM-2025-06 дугаар 31 /бусад/ нийт 37 ш
- Нэмэлт гэрээний- 93 төсөл

Enterprise resource planning /ERP/ системийн Гэрээний бүртгэлийн модуль-Гэрээний бүртгэлийг гэрээ батлагдан гарсан даруй хөтөлж, тухайн оны нийт гэрээний хэрэгжилтийг дүгнэж, ажилласан.

## 10.5. Даатгалд хамрагдах, нөхөн төлүүлэх


- “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-т 2025 онд тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, жолоочийн хариуцлагын 6 ослын тохиолдол гарсан бөгөөд Даатгалын нөхөн төлбөрийн материалыг 4 тохиолдолд бүрдүүлж, харьяа үйлдвэр болон даатгалын байгууллагуудтай хамтарч ажилласан.
- “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-т 2025 онд Гэнэтийн ослын 2 тохиолдол гарсан бөгөөд 1 даатгалын нөхөн төлбөрийн материалыг бүрдүүлж, харьяа үйлдвэр болон даатгалын байгууллагуудтай хамтарч ажилласан.
- “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-ын нь “Хаан даатгал” ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр MR-2025-06-04 дугаар “Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, жолоочийн хариуцлагын даатгал”-ын гэрээг байгуулан “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын өмчлөлийн тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, жолооч нарыг тус тус даатгуулсан ба даатгалын гэрээний төслийг хянаж боловсруулан, батлуулсан.
- “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ нь “Ард даатгал” ХК-тай 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр MR-2025-06-05 дугаар “Гэнэтийн ослын даатгал”-ын гэрээг байгуулан “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын 1525 ажилтныг даатгуулсан ба даатгалын гэрээний төслийг хянаж боловсруулан, батлуулсан.
- “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ нь 2025 онд нийт 72,097,277 төгрөгийн нөхөн төлбөр авсан ба үүнээс “Хаан даатгал” ХХК-иас 6,797,277 төгрөг, “Ард даатгал” ХК-иас 65,300,000 нөхөн төлбөрийг тус тус авсан байна. Даатгалын нөхөн төлбөрийн материалыг тухай бүр бүрдүүлж, харьяа үйлдвэр болон даатгалын байгууллагуудтай хамтарч ажилласан.

## 10.6. Төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах

Үйлдвэрийн газрын үндсэн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлэх, үйл ажиллагааг ил тод байлгах зорилтын хүрээнд үндсэн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цахим хуудасны мэдээлэл цэсэд мөн, үйлдвэрийн газрын шинээр зарлагдаж буй ажлын байрны зарыг өөрийн цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн шугамаар нийтлэн ажиллаж байна.

## 10.7. Нийтийн мэдээллийг ил тод байлгах зорилтын хүрээнд

“Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ нь “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн хэрэгжилтийн хүрээнд Үйлдвэрийн газрын цахим хуудас болох [www.ecmm.mn](http://www.ecmm.mn) цахим хуудсанд Үйл ажиллагаа, Хүний нөөц, Хууль эрх зүйн ил тод байдал гэх 3 төрлийн дэд цэс шинээр үүсгэж, хуульд заасан мэдээллийг цаг тухай бүрд шинэчлэн оруулан ажиллаж байна.

 "ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС" ТӨҮГ

ЭХЛЭЛ БИДНИЙ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ ТЕНДЕР ИЛ ТОД БАЙДАЛ ШИЛЭН ДАНС ХОЛБОО БАРИХ +26 / ☰

---

Санхүүгийн мэдээлэл

Удирдлага

Үйл ажиллагааны ил тод байдал


Хүний нөөцийн ил тод байдал

Хууль, Эрх зүйн ил тод байдал

Тусгай зөвшөөрлүүд

### ИЛ ТОД БАЙДАЛ

Сул орон тоо



## 11. ХӨНДЛӨНГИЙН БОЛОН ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь 2012 оноос эхлэн Монгол Улсын “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг үндэслэн “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, төрийн эрх бүхий бусад байгууллагын шийдвэр, хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрмийн хэрэгжилт, хувийн ашиг сонирхлын зөрчил, эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, түүнд заасан Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, салбар үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалт хийх, дүгнэлт зөвлөмж өгөх, хяналт тавьж ажиллах чиглэлээр байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэх үүрэг бүхий бие даасан нэгж болох Дотоод хяналт, мониторингийн хэлтэс ажиллаж байна.

### 11.1. Дотоод хяналт шалгалтын чиглэлээр:

- ТӨҮГ-ын захирлын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/181 дүгээр “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” тушаалаар ажлын хэсэг байгуулагдан 2025 оны 05 дугаар сарын 21-нээс 25-ны өдрүүдэд "Бор-Өндөр" УБҮ-т ажиллаж, ажлын хэсгийн тайлан боловсруулж, зөвлөмж гаргаж ажилласан. ТӨҮГ-ын захирлын зөвлөмжийг хэрэгжүүлэх тушаал гаргаж, зөвлөмжийн биелэлтийг хангуулахаар тайлан авч ажиллаж байна. 2026 оны 02 дугаар сард тус шалгалгалтаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд эргэн хяналт, үнэлгээ хийхээр төлөвлөсөн.
- ТӨҮГ-ын захирлын 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/132 дугаар Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тушаалын дагуу ТӨҮГ-ын захиргааны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж ажилласан. Ажлын хэсгийн тайлан, зөвлөмжийн дагуу ТӨҮГ-ын захирлын зөвлөмжийг хэрэгжүүлэх тушаал гаргаж, зөвлөмжийн биелэлтийг хангуулахаар ажиллаж байна. Тус тушаалаар 2026 оны улирал бүрийн дараа сард зөвлөмжийн биелэлтийн тайланг ирүүлж байхаар тусгасан.
- ТӨҮГ-ын захирлын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/158 дугаар Төлөвлөгөөт шалгалт хийх тушаалын дагуу “Шижир-Алт” АҮ-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж ажилласан. Ажлын хэсгийн тайлан, зөвлөмжийн дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ТӨҮГ-ын захирлын тушаал гаргаж, зөвлөмжийн биелэлтийг хангуулахаар ажиллаж байна. Тус тушаалаар 2026 оны улирал бүрийн дараа сард зөвлөмжийн биелэлтийн тайланг ирүүлж ажиллахаар тусгасан.
- ТӨҮГ-ын 2025 оны 05 дугаар сарын 20-ны А/71 дугаар тушаалаар байгуулагдсан ТӨҮГ-ын эзэмшлийн хайлуур жоншны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах гэрээний биелэлтэд хяналт тавих, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулж ажиллах зорилготой ажлын хэсэг ажиллаж байна.

- 2025 онд нийт 351 удаагийн тендер шалгаруулалтын Үнэлгээний хорооны шийдвэрт хяналтын дүгнэлт гаргаж ажилласан байна. Мөн ТӨҮГ-ын захиргааны хяналт шалгалтын хүрээнд худалдан авах үйл ажиллагаанд Монополын эсрэг газар, Сангийн яаманд гаргасан гомдол, шийдвэрт дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргаж ажилласан. 2025 оны Худалдан авах төлөвлөгөөний гүйцэтгэл үнийн дүнгээр 99%-тай, бараа, ажил, үйлчилгээний тоон дүнгээр 89%-ийн гүйцэтгэлтэй байна.

## **11.2. Эрсдэлийн удирдлагын чиглэлээр:**

Үйлдвэрийн газрын Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, Үйлдвэрийн газрын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх жишиг аргачлалын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд :

- "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/146 тоот тушаалаар ТӨҮГ-ын бүх бүтцийн нэгжийн эрсдэлийг бүртгэх, үнэлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж биелэлтийг тайлагнах үүрэг бүхий 49 ажилтанг томилсон.
- 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/147 тоот тушаалаар 2025 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэл, түүний хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр "Эрдэнэс монгол" ХХК-д хүргүүлэн ажилласан.
- 2025 онд 133 эрсдэлийн хариу арга хэмжээг авч хэрэгжүүлснээр өндөр түвшинд эрэмбэлэгдсэн 47 эрсдэлээс 5 болж буурсан, дунд түвшний 74 эрсдэлээс 37 эрсдэл болж буурсан. Өндөр, дунд түвшнээс нийт 79 эрсдэл бага түвшин хүртэл буурч, нийт бага түвшний эрсдэл 91 болсон байна.
- "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитын газраас зохион байгуулсан "Эрсдэлд суурилсан дотоод аудитын тогтолцоог бэхжүүлэх" сургалтад ДХМХ-ээс 4 ажилтан хамрагдсан.
- "Бор-Өндөр" Уулын баяжуулах үйлдвэрийн эрсдэлийн асуудал хариуцсан 29 мэргэжилтнийг чадавхжуулах чиглэлээр "Эрсдэлээ зөв тодорхойлж, хариу арга хэмжээ авах" сэдэвт эрсдэлийн менежментийн анхан шатны сургалтыг зохион байгуулсан.
- "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын харьяа "Шижир-Алт" Алтны үйлдвэрийн эрсдэл хариуцсан мэргэжилтнүүдэд "Эрсдэлээ зөв тодорхойлж, хариу арга хэмжээ авах" сэдэвт эрсдэлийн менежментийн анхан шатны сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явц, эрсдэлийн ангилал, эрсдэлийн төрөл, эрсдэлийн хариу арга хэмжээний тухай ойлголтыг олгосон.
- Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг сурталчлан таниулах сарын аяны хүрээнд "Эрдэнэс монгол" нэгдлийн ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитын газартай хамтран Удирдлагын академийн "Б" зааланд 2025 оны 05 сарын 21-ний өдөр "Эрдэнэс Монгол" нэгдлийн харьяа 30 гаруй компанийн нийт 100 гаруй хүмүүсийг хамруулсан "Эрсдэлд суурилсан төлөвлөлт" сэдэвт 8 цагийн багц сургалтыг амжилттай зохион байгуулсан. Энэхүү сургалтад ТӨҮГ-ын захиргаанаас 10, "Бор-Өндөр" УБҮ-ийн 29 нийт 39-н бүтцийн нэгжийн эрсдэл хариуцсан ажилтан хамрагдсан.

### 11.3. Олон улсын нэгдсэн менежментийн тогтолцоо

Олон улсын нэгдсэн менежментийн тогтолцооны шаардлагуудыг хангах, үйлдвэрийн газарт нэгдсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

- Нэгдсэн менежментийн тогтолцооны ISO9001:2015, ISO14001:2015, ISO45001:2018 хэрэгжилтэд магадлах 1 аудитыг "Монсертф" ХХК-иар 2025 оны 02 дугаар сарын 04-нөөс 06-ны өдрүүдэд хийгдсэн. Тус аудитаар жижиг үл тохирол-3 бүртгэгдсэн. Илэрсэн үл тохирлыг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
- MNS ISO/IEC 27001:2023 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлж, 2025 оны 12 дугаар сард баталгаажуулах аудит хийлгэсэн.
- Нэгдсэн менежментийн тогтолцооны ISO9001:2015, ISO14001:2015, ISO45001:2018-ын аудитын менежерээр 1, дотоод аудитораар 15 ажилтан хамрагдан гэрчилгээ авсан. Чанарын менежментийн тогтолцоо /ISO9001:2015/-ны тэргүүлэх аудитор 1, MNS ISO/IEC 27001:2023 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тэргүүлэх аудитор 1, дотоод аудитор 9 ажилтан сургалтад хамрагдан гэрчилгээг авсан.
- “Бор-Өндөр” УБҮ-ийн 2024 оны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын үеэр Нэгдсэн менежментийн тогтолцооны талаарх мэдээлэл хүргэх сургалтыг “Бор-Өндөр” УБҮ-т зохион байгуулсан ба нийт 33 ажилчин хамрагдсан.

### 11.4. Бусад

Авлигатай тэмцэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд Авлигатай тэмцэх газар, “Эрдэнэс Монгол” ХХК-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- 2025 онд нийт 15 хүний ХАСУМ-ийг хянуулахаар АТГ-т хүргүүлсэн. Үүнд: Шинээр томилогдсон 6, албан тушаал шилжин томилогдсон 2, дэвшин томилогдсон 5, чиг үүрэг өөрчлөгдсөн 2 албан тушаалтан байна. Албан тушаал өөрчлөгдөн томилогдсон 2, шинээр томилогдсон 2, хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсон 5 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан баталгаажуулсан.
- “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын захирлын 2025 оны 4 дүгээр сарын 18-ны А/39 дугаар тушаалын хавсралтаар “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”, А/38 дугаар тушаалын хавсралтаар “Авлигын эсрэг үйл ажиллагааны журам”-ыг тус тус батлуулан ажиллаж байна.
- АТГ-аас авлигын эсрэг үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх чиглэлийн сургалт авахаар 2025.04.03-ны өдөр цахимаар хүсэлтээ илгээсэн. ТӨҮГ-ын харьяа “Бор-Өндөр” УБҮ-т авлигын эсрэг сургалт авахаар 2025.06.06-ны өдөр АТГ-ын цахим хуудсаар, 2025.06.16 өдрийн 1/889 дугаар албан бичгээр тус тус хүсэлт хүргүүлсний дагуу АТГ-аас 2025.11.20-ны өдөр Авлигын эсрэг сургалтыг цахимаар зохион байгуулсан ба сургалтад “Бор-Өндөр” УБҮ-ээс нийт 110 ажилтан хамрагдсан.

- ТӨҮГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны журмын 10.2-т тусгагдсан Бүх төрлийн гэрээ байгуулахдаа “Талууд нь авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, авлигаас урьдчилан сэргийлж, авлигын талаарх мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэж ажиллана” гэсэн агуулга бүхий заалтыг тусгуулсан.
- ТӨҮГ-ын алтны үйлдвэрт алт хамгаалах журмыг хэрэгжүүлэх хүрээнд ТӨҮГ-ын захиргааны ажилчдыг “Шижир-Алт” АҮ-т алтны угаах, баяжуулах үйл ажиллагаа явагдах хугацаанд долоо, долоо хоногийн ээлжээр алтны хяналтаар ажиллуулсан. Тухайн комиссын ажлын тайланг тухай бүр авч, холбогдох арга хэмжээг авч ажилласан.
- Улирал бүр ТӨҮГ-ын шилэн дансны хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийн тайланг Эрдэнэс Монгол ХХК-ийн ДХЭУГ-т хүргүүлж ажилласан.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 78 дугаар тогтоолоор өгсөн үүрэг, даалгавар, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 23-ны байдлаар хүргүүлсэн.